



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



---

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ - 2021 ОНЫ I УЛИРАЛ

---



Улаанбаатар хот  
2021 он


## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжиж буй болон хөгжингүй зах зээлтэй орнуудын санхүүгийн зах зээлд макро эдийн засаг болон мөнгө, сангийн бодлогын нөлөөлөх хувьсагч үзүүлэлтүүдийн талаарх судалгааг хийж, холбогдох бодлогын зөвлөмжүүдийг тогтмол олон нийгэд хүргэх ажлыг хийж гүйцэтгэдэг бөгөөд дээрх байгууллагуудаас үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны төвлөрөл, хувьцааны индекс гэсэн үндсэн хэсгүүдэд хуваан авч үздэг.

### 1.1. Зах зээлийн үнэлгээ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 оны 1-р улирлын байдлаар 3.7 их наяд төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.5 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд ДНБ-д харьцуулахад 10 хувийг эзэлж байна.

График 1. Зах зээлийн үнэлгээ



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлэгч арилжаа эрхлэх байгууллагуудад бүртгэлтэй нийт 186 компаниас 30 компанийн зах зээлийн үнэлгээ 92.3 хувийг бүрдүүлж байна. Үүнд:

Хүснэгт 1. ЗЗҮ хамгийн өндөр 30 компани /тэрбум төгрөгөөр/

д/д	Компанийн нэр	Зах зээлийн үнэлгээ	д/д	Компанийн нэр	Зах зээлийн үнэлгээ
1	АПУ ХК	793.60	16	МАНДАЛ ДААТГАЛ	41.73
2	ТАВАН ТОЛГОЙ	390.25	17	АРД ДААТГАЛ ХК	36.38
3	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	291.29	18	ГУТАЛ	35.60
4	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	247.79	19	ЛЭНДМН ББСБ	34.14
5	МИК ХОЛДИНГ	234.43	20	ДАРХАН НЭХИЙ	31.42
6	ИНВЕСКОР ББСБ	228.45	21	МОНОС ХҮНС	29.56

7	ГОВЬ	189.57	22	БОДЬ ДААТГАЛ	29.53
8	МОНГОЛ ШУУДАН ХК	168.70	23	ШИВЭЭ ОВОО	21.87
9	МОНГОЛ ДААТГАЛ	116.72	24	БАГАНУУР	20.58
10	УБ-БҮК	80.24	25	ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ	19.12
11	СҮҮ	73.01	26	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	17.00
12	АРД КРЕДИТ ББСБ	68.45	27	БИ ДИ СЕК	16.02
13	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	60.66	28	ТЕХНИК ИМПОРТ	14.80
14	БЭРХ УУЛ	46.28	29	ТАЛХ ЧИХЭР	14.54
15	ТҮМЭН ШУВУУТ	42.74	30	ТАХЬ-КО	14.28
<b>Нийт дүн</b>					<b>3,408.75</b>
<b>Нийт ЗЗҮ-нд эзлэх хувь</b>					<b>92.3%</b>

### 1.2. Хөрвөх чадвар

Дэлхийн банкнаас гаргасан үзүүлэлтээр дэлхийн улс орнуудын хөрвөх чадварын дундаж үзүүлэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 88.4 хувь байгаа бол Монгол Улсын багтдаг ангилал буюу дунджаас бага орлоготой орнуудын дундаж үзүүлэлт 45.4 хувь байна.

Монгол Улсын хувьд хөрвөх чадвар 1.4 пунктээр өсч 1.8 хувьд хүрсэн бөгөөд хувьцааны арилжаа 6.7 дахин өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Хөрвөх чадварын үзүүлэлт олон улсын дундаж үзүүлэлттэй харьцуулахад маш бага түвшинд байгаа нь голчлон хувьцааны төвлөрөлтэй хамааралтай байна.

Тухайлбал, ТОП-20 индексэд багтаж буй компаниудын хувьцаа эзэмшлийн хувь хэмжээг харахад нийт хувьцааны 80.3 хувийг нийт хувьцаа эзэмшигчдийн 0.05 хувь нь эзэмшиж байна.

### 1.3. Үнэт цаасны зах зээлийн индексүүд

Монголын хөрөнгийн бирж дээр ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. Зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 35,378.87 нэгж, доод үзүүлэлт 19,024.52 нэгж, дундаж үзүүлэлт 26,872.31 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17,732.00 нэгжээр буюу 104.90 хувиар өсч, 34635.65 нэгж болсон байна.

ТОП-20 индексийн өсөлтөд индексийн сагсыг бүрдүүлж буй “Ард санхүүгийн нэгдэл” ХК /571.06%/, “Ард кредит ББСБ” ХК /215.03%/, “Монгол шуудан” ХК /152.84%/, “Ард Даатгал” ХК /102.08%/, “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК /84.96%/, “Улсын их дэлгүүр” ХК /60.35%/-ийн ханш тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-иас 2018 онд үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хамаарах MSE-A болон MSE-B индексийг тооцон гаргадаг болсон. MSE-A индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,235.25 нэгжээр буюу 28.2 хувиар өсч, 10,149.32 нэгж болсон бол MSE-B индексийн дээд үзүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,950.39 нэгжээр буюу 51.57 хувиар өсч, 11,610.58 нэгж болсон байна.

## Хүснэгт 2. Индексийн үзүүлэлт

Индекс	2020.03.31	2021.03.31	Өөрчлөлт
ТОП 20	16,903.65	34,635.65	104.90%
MSE A	7,914.07	10,149.32	28.24%
MSE B	7,660.19	11,610.58	51.57%


## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

### 2.1. Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт

Тайлант хугацаанд нийт 71.8 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагууд дээр өмнөх онуудад зөвхөн хувьцаа, өрийн хэрэгсэл, ЗГҮЦ гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагддаг байсан бол 2020 онд анх удаа хамтын хөрөнгө оруулалтын сан СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан бол 2021 оны 1-р улиралд хамгийн анхны нийтэд санал болгох хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас анхдагч зах зээл дээр амжилттай арилжаалагдсан.

Ингэснээр тайлант хугацаанд нийт арилжааны 91.8 хувийг хувьцаа, 0.6 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 1.8 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 5.8 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна. Үүнд:

График 2. Арилжааны хэмжээ-Бүтээгдэхүүнээр



Нийт үнэт цаасны арилжааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 дахин өссөн байгаад хувьцааны арилжаа 6.7 дахин өссөн мөн шинэ төрлийн бүтээгдэхүүнүүд арилжаалагдаж эхэлсэн нь нөлөөлсөн байна.

Харин хөдөө аж ахуйн биржээр тайлант хугацаанд зөвхөн 5 төрлийн нийт 69.3 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 41.0 тэрбум төгрөгөөр буюу 145.1 хувиар өссөн байна.

#### 2.1.1. Хувьцааны арилжаа

2021 оны 1-р улиралд нийт 65.9 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.7 дахин өссөн байна.

“МХБ” ХК-иар 2021 оны 1-р улиралд нийт 61 удаагийн арилжаагаар 114 хувьцаат компанийн 245.6 сая ширхэг хувьцааг 65.9 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт 114 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64 компанийн үнэт цаасны ханш өсч, 38 компанийн үнэт цаасны ханш буурч, 12 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна. Харин тайлант хугацаанд “МҮЦБ” ХК-иар арилжаа хийгдээгүй байна.

Хувьцааны арилжааг “МХБ” ХК дээр бүртгэлтэй нийт 186 компаниар ангилвал 30 компанийн хувьцааны арилжааны дүн нийт арилжааны 99.42 хувийг бүрдүүлж байна. Үүнд:

**Хүснэгт 2. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компани**

№	Компанийн нэр	Арилжааны үнийн дүн	№	Компанийн нэр	Арилжааны үнийн дүн
1	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	32,902,372,303.00	16	МЕРЕКС	397,323,276.96
2	АРД КРЕДИТ ББСБ ХК	9,505,176,103.12	17	МОНГОЛ ШУУДАН ХК	394,973,316.79
3	АРД ДААТГАЛ ХК	6,668,312,698.92	18	ДАРХАННЭХИЙ	247,732,664.36
4	БОДЬ ДААТГАЛ ХК	2,677,256,134.49	19	СҮҮ	241,403,444.56
5	АПУ	2,041,732,306.83	20	ИНВЕСКОР ББСБ	235,481,631.00
6	МАНДАЛ ДААТГАЛ	1,852,059,433.28	21	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	189,145,524.00
7	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	1,102,599,347.97	22	МОНГОЛ БАЗАЛЫТ ХК	132,002,589.26
8	ЛЭНДМН ББСБ ХК	1,088,812,253.60	23	Е-МОНИЕ	115,323,575.00
9	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	1,025,307,101.50	24	АЙТҮҮЛС	111,077,452.78
10	БИ ДИ СЕК	1,015,651,857.80	25	УБ-БУК	101,112,427.28
11	ШАРЫН ГОЛ	811,582,070.24	26	РЕМИКОН	93,222,837.03
12	ГОВЬ	673,006,862.60	27	ЖЕНКО ТУР БЮРО	77,741,597.64
13	ТҮМЭНШУВУУТ	615,132,014.10	28	БУЛГАН УНДРАГА	58,280,815.92
14	МОНОС ХҮНС	581,415,585.31	29	ТАЛХЧИХЭР	56,857,580.00
15	ТАВАН ТОЛГОЙ	475,171,080.00	30	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	55,264,241.87
<b>НИЙТ</b>					<b>65,542,530,127.21</b>

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

**2.1.1.1. Багцын арилжаа**

Тайлант хугацаанд хувьцааны хоёрдогч зах зээл дээр 7 ХК-ийн 75.9 сая ширхэг хувьцааны нийт 16,132,903,756.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа

хийгдсэн ба энэ нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 24.5 хувийг эзэлж байна.

### Хүснэгт 3. Багцын арилжаа хийгдсэн компаниуд

№	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг /мян. ширхэг/	Үнийн дүн /тэр. төг/
1	Бодь даатгал	19,800.00	2.42
2	Эрдэнэ ресурс девелопмент	786.26	0.79
3	Өндөрхаан	35.8	0.04
4	Лэндмн ББСБ	8,334.00	0.25
5	Мандал даатгал	11,516.60	0.53
6	ЕМоние	52.93	0.12
7	Ард санхүүгийн нэгдэл	1,771.13	9.07
8	Ард даатгал	890.11	0.87
9	БиДиСек	460	0.64
10	Стандарт агрикалчер групп	13,607.87	1.02
11	Мерекс	18,679.25	0.4
<b>Нийт</b>		<b>75,933.33</b>	<b>16.13</b>

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

#### 2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

Монголын хөрөнгийн зах зээл дээр 2001-2020 онуудад нийт 17 компани нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргаснаас 2021 оны 1-р улирлын байдлаар “Лэндмн ББСБ” ХК-ийн бонд арилжаалагдаж байна. Тайлант хугацаанд тус компанийн 4.6 мянган ширхэг бондыг 465.1 сая төгрөгөөр арилжсан байна.

#### 2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойших хугацаанд 2021 оны 1-р улирлын байдлаар нийт 25 хөрөнгө оруулалтын менежментийн компани тусгай зөвшөөрөл авсан байна. 2020 онд анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох “Үндэсний хувьчлалын сан” СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан бөгөөд тайлант хугацаанд хоёрдогч зах зээл дээр тус сангийн нийт 7,163,109 ширхэг нэгж эрхийг 1.31 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

#### 2.1.4. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн биржээр нийт 63.9 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 41.0 тэрбум төгрөгөөр буюу 145.1 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд дараах 5 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан байна. Үүнд:

Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



### 2.1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зорилгоор 2013 оноос ипотекийн бага хүүтэйгээр орон сууцны зээлийг иргэдэд олгож эхэлсэн. Өнөөгийн байдлаар “МИК ОССК” ХХК-аас 25 ТЗК үүсгэн байгуулж, нийт 83,539 зээлдэгчийн ипотекийн зээлийг үнэт цаасжуулж 4.4 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг СЗХ-нд бүртгүүлээд байгаа бол 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 63,850 зээлдэгчийн 3.03 их наяд төгрөгийн баталгаат үнэт цаасны үлдэгдэлтэй байна.

Мөн үүрэн телефоны оператор болох “Жимобайл” ХХК нь 2019 оны 5 дугаар сард нийт 7.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан нь үл хөдлөх хөрөнгийн зээлээс өөр төрлийн санхүүгийн хэрэгслээр баталгаажсан үнэт цаас гаргасан анхны тохиолдол болсон бөгөөд 2021 оны 1-р улирлын эцсийн байдлаар нийт 1.525 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Үүний зэрэгцээ ковид цар тахлын онцгой нөхцөлд ажиллаж буй төрийн албан хаагчдыг түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцны хөтөлбөрт хамруулах хүрээнд түрээсийн орлогод суурилсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, шаардлагатай санхүүжилтийн шийдвэрлэхийг хууль болон УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолоор ЗГ, Монголбанк, СЗХ-нд даалгасан. СЗХ-ноос “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн үүсгэн байгуулсан тусгай зориулалтын компаниудад түрээсийн орлогоор баталгаажсан буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгож, “НОСК нэг ТЗК” ХХК-ийн 34.4 тэрбум, “НОСК хоёр ТЗК” ХХК-ийн 39.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгээд байна.

Хэдийгээр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль батлагдсанаас хойш 10 орчим жилийн хугацаа өнгөрсөн ч энэ төрлийн үнэт цаасыг зөвхөн цөөн тооны мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгон гаргаж байсан бол 2020 онд анх удаа СЗХ-нд автомашины зээлээр баталгаажсан нийтэд буюу иргэдэд чиглэсэн зах зээлийн шинэ бүтээгдэхүүнийг “Инвескор актив” ХХК бүртгүүлж, 2021 оны 01-р сард анхдагч зах зээл дээр амжилттай гарган нийт 4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн ба 1-р улирлын байдлаар хоёрдогч зах зээл дээр нийт 141.04 сая төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

### 2.2. Үнэт цаасны зах зээлийн эрэлт

Тайлант хугацаанд 11,822 данс нээгдэж өссөн дүнгээр нийт 2,385,822 данс нээгдсэн байна. Мөн онд 24,448 холболтын данс нээгдэж нийт 401,882 холболтын данс нээгджээ.

### 2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

“Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-иас ирүүлсэн тайлангаар тайлант хугацаанд гадаадын ААН, гадаадын иргэдийн хийсэн арилжаа нийт хийгдсэн арилжааны 13.14 хувийг эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 10.47 нэгжээр буурсан байна.

Нийт арилжаанд дотоодын аж ахуйн нэгж 38.1 хувь, дотоодын иргэн 59.9 хувийг тус тус эзэлж байна.

Мөн үнэт цаасны дансны тухайд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д өссөн дүнгээр нийт 2,397,644 данс нээгдээд байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 17,145 этгээд арилжаанд оролцжээ.

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг СЗХ хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан 142, үнэт цаасаа бүртгүүлсэн 312 ХК, хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг нь бүртгэсэн 23, үнэт цаасны зах зээлд хууль, үнэлгээ, аудитын үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгүүлсэн 120 этгээд байна.

#### Хүснэгт 5. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
<b>Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа</b>		
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага	2
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	25
5	Хамтын хөрөнгө оруулалтын сан	1
6	Кастодиан	3
7	Үнэт цаасны компани /брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх/	55 <sup>1</sup>
8	Хөрөнгө итгэмжлэн удирдах	7
9	Үнэт цаасны итгэмжлэн удирдах	1
10	Хөдөө аж ахуйн бирж	1
11	Хөдөө аж ахуйн брокер	14
12	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах	30

<sup>1</sup> Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк орсон болно.

<b>Хувийн ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн</b>		
13	Хувийн ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгээ бүртгүүлсэн	23
<b>Бүртгэлтэй ХК-ийн тоо</b>		
14	Хувьцаат компани	312
<b>Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн байгууллагууд</b>		
15	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх	60
16	ҮЦЗЗ-д оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх	25
17	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх	35

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР СЗХ-НООСАВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ**

### *1. Банкны түр журам*

УИХ-аас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд *“Банкийг нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг энэ хуульд нийцүүлэн өөрчлөх, энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах хянах түр журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална”* гэж заасан.

Үүний дагуу Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А-90/85 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар **“Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам”**-ыг баталсан.

Дээрх түр журмаар банкныг нээлттэй болон хаалттай хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хуульд нийцүүлэн өөрчлөх ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, банк хувьцаагаа нийгэд болон хаалттай хүрээнд санал болгох төлөвлөгөө, нэгж хувьцааг санал болгох үнийн төсөөлөл, боломжит хөрөнгө оруулагчдын тандан судалгаа зэргийг тусгасан төлөвлөгөөг Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкинд ирүүлэх мөн төлөвлөгөөг хянахтай холбогдсон харилцааг зохицуулах юм. Түр журмын зохицуулалт хэрэгжиж эхэлснээр банкууд компанийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болох, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах төлөвлөгөөг боловсруулж 2021 оны долдугаар сарын 01-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкинд ирүүлэх юм. Монгол Улсын хөрөнгийн зах зээлд дотоодын томоохон банкууд буюу банкны системд нөлөө бүхий банкууд компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулж, нээлттэй хувьцаат компани болсноор чанартай, өндөр хөрвөх чадвартай бүтээгдэхүүн бий болох, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх сонирхол нэмэгдэх, улмаар олон тулгуурт санхүүгийн зах зээл бий болох нөхцөл бүрдэх юм.

### *2. Зах зээлийн шимтгэл, хураамжийг бууруулах хүрээнд*

УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-д туссан “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах” чиглэлд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах ажлын хэсгээс зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг

бууруулах чиглэлээр 2020 онд “ҮЦТХТ” ХХК-ийн анхдагч зах зээл дэх арилжааны шимтгэл 0.24% байсныг 50 хувиар бууруулж 0.12% болгосон бол 2021 оны нэгдүгээр улиралд “МҮЦКТ” ХХК-ийн хоёрдогч зах зээлийн арилжааны шимтгэлийг хэлцэл тус бүрээс 0.12% болгон 50 хувиар бууруулсан.

### *3. Журмыг шинэчлэн батлах ажлын хүрээнд*

• “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулж, СЗХ-ны 2020 оны 995 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар олон улсын жишигт нийцсэн биржийн бус зах зээл хөгжих үндэс суурь тавигдаж, компанийн хаалттай өрийн хэрэгслийг зохицуулсан хууль, эрх зүйн нарийвчилсан зохицуулалт бий болж, компаниудын зүгээс үнэт цаас гаргахад цаг хугацаа, зардал хэмнэх боломж нээгдэхийн зэрэгцээ мэргэжлийн хөрөнгө оруулагч нарт чиглэсэн зах зээл бий болсон. Журамд биржийн бус зах зээлийг удирдан зохион байгуулах үүргийг “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” хүлээхээр тусгасан бөгөөд биржийн бус зах зээлийг хөгжүүлэх, биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангахаар тогтмол хамтран ажиллаж байна.

• УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг баталсан бөгөөд уг стратеги батлагдсантай холбогдуулан үнэт цаасны бүртгэлийн болон хувьцаат компанийн мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, компанийн бонд гаргахад тавигдах шалгуур, шаардлагыг багасгаж, зохицуулалтын орчинг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажлуудыг тусгасан.

Үүний дагуу компанийн өрийн хэрэгслийг хувьцааны бүртгэлээс хөнгөвчилсөн, бүтээгдэхүүний онцлогт нийцүүлэн бүртгэх, компанийн бонд гаргахад Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хийгддэг хяналтын ажиллагааны давхардлыг арилгах, бүртгэлийн үйл ажиллагааны хугацааг багасгах нөхцөлийг тусгасан “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын төслийг боловсруулсан. Түүнчлэн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй этгээд бонд гаргахад хялбаршуулсан журмаар бүртгүүлэх, мөн нэг удаа бүртгүүлсэн бондыг тодорхой үе шаттайгаар буюу эх үүсвэрийн шаардлагатай үед хэсэгчлэн гаргах зохицуулалтыг журмын төсөлд тусган боловсруулсан.

Мөн Хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д өөрчлөлт оруулж нийгэд санал болгон хувьцаа гаргах ажиллагаа, үе шат, андеррайтерийн компанийн үүрэг хариуцлага, андеррайтерийн захиалга авах хэлбэр, хууль, үнэлгээ, аудитын компаниудад тавигдах шаардлага түүний үйл ажиллагааны зохицуулалт, үнэт цаас гаргагч компанийн ирүүлэх мэдээлэл, маягтын талаар IOSCO зарчмууд болон олон улсын зохицуулалт, зөвлөмжийг судалж, журмын төсөлд тусгаж боловсруулаад байна.

Дээрх 2 журмын төсөлд Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу олон нийт болон мэргэжлийн байгууллагуудын холбогдох санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

## **ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР**